



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Засгийн газрын авто бааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 169,800,000.00 (нэг зуун жаран есөн сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 2,316,000.00 (хоёр сая гурван зуун арван зургаан мянган) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврагч биеийн тамир, техник спортын хороонд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, "Засгийн газрын авто бааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Аврагч биеийн тамир, техник спортын хорооны дарга, хурандаа Г.Эрхэмбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн ёмчийн бодлогого зохицуулалтын газрын  
2020 оны дугаар сарын 18-ний өдрийн  
37. дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТҮЙ УЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЧУДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВРАЛЧ БИЕИН ТАМИР,  
ТЕХНИК СПОРТЫН ХОРООНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭТСЭН

Д/д	Автомашины нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан инфинити QX56 (арал-jn8azz2ne2b9007321)	2011	77294	169,800,000.00	167,484,000.00	2,316,000.00
	Нийт дүн			169,800,000.00 (нэг зуун жаран есөн сая найман зуун мянган)	167,484,000.00 (нэг зуун жаран долоон сая дөрвөн зуун наян зуун мянган)	2,316,000.00 (хоёр сая гурван зуун арван зураган мянган)